



ӨВӨР МОНГОЛЫН ТАЙЗНЫ БҮЖГИЙН ХӨГЖИЛД НЭРТ БҮЖИГ ДЭГЛЭЭЧ ЖЯ ЗУО ГУАНЫ ОРУУЛСАН ХУВЬ НЭМРИЙГ ТОДРУУЛСАН НЬ

А.Оюунтунгалаг^а, Б.Шилийнхүү/Xilinfu^б, Ж.Эрдэнэхорлоо^в

^аМУБИС-Багшийн сургууль, дэд профессор, доктор;

^бӨвөр Монголын Урлагийн дээд сургууль, багш, магистр;

^вСУИС-Бүжгийн урлагийн сургууль, тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор

Холбоо барих зохиогч: oyuntungalaga@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Хятадын бүжгийн нэрт зүтгэлтэн, орчин үеийн бүжгийн анхдагчдын нэг, бүжиг дэглээч Жя Зуо Гуан Өвөр Монголын ард түмний ахуй амьдрал, соёл урлаг, ардын бүжгийг судалж дэглэсэн бүтээлээрээ орчин цагийн Өвөр Монгол тайзны бүжгийн суурийг тавьж, хөгжүүлсэн юм. Иймд Жя Зуо Гуаны өвөр монгол бүжиг дэглэсэн арга туршлагыг гүнзгийрүүлэн судлах нь чухал юм. 1947 онд Жя Зуо Гуан Өвөр Монголд ирж, Өвөр Монголын дуу бүжгийн бүлгэмд бүжигчин, бүжиг дэглээчээр ажиллах болов. Энд ирээд хэд хэдэн Өвөр Монгол алдартай бүжгээ дэглэсэн.

Түлхүүр үг

Түүх, үндэсний соёл, монгол зан заншил, үндэсний өвөрмөц бүжиг, бүжиг дэглэх

Удиртгал

Хятадын бүжгийн нэрт зүтгэлтэн, орчин үеийн бүжгийн анхдагчдын нэг, бүжиг дэглээч Жя Зуо Гуан Өвөр Монголын ард түмний ахуй амьдрал, соёл урлаг, ардын бүжгийг судалж дэглэсэн бүтээлээрээ орчин цагийн Өвөр Монгол тайзны бүжгийн суурийг тавьж, хөгжүүлсэн юм. Иймд Жя Зуо Гуаны Өвөр монгол бүжиг дэглэсэн арга туршлагыг гүнзгийрүүлэн судлах нь зайлшгүй чухал юм.

Хятадын сурган хүмүүжүүлэгч, профессор Жя Зуо Гуан “Манж үндэстний киноны сургууль”-ийн тоглогчийн бэлтгэл ангид суралцаж байгаад Японд очиж, японы орчин үеийн бүжгийн эцэг - Иши Итакугийн удирдлага дор бүжгийн боловсрол эзэмшжээ.

1947 онд Жя Зуо Гуан, хятадын орчин үеийн бүжгийн нэрт төлөөлөгчийн нэг Ү Сяо Бантай хамт Өвөр Монголд ирж, Өвөр Монголын дуу бүжгийн бүлгэмд бүжигчин, бүжиг дэглээчээр ажиллах болов. Энд ирээд дэглэсэн анхны уран бүтээл бол

“Адуучны бүжиг”, “Орчон бүжиг”, “Хун галуу” зэрэг бүжиг юм. Өвөр Монголд ирээд анх “Адуучны бүжиг” хэмээх гоцлол бүжиг дэглэж, өөрөө бүжиглэсэн байна. Тус бүжгийг 1949 онд Унгар улсад болсон Дэлхийн залуучууд оюутны II их наадамд бүжиглэж, анх удаа өвөр монгол бүжгийг дэлхийн тайзнаа гаргасан байна.

Жя Зуо Гуан “Адуучны бүжиг”-ээ Монгол улсын үзэгчдэд ч толилуулсан байна. БНХАУ тунхагласны 3 жилийн ойд зориулж 1952 оны 10 сарын 01-10 нд “Монгол, Хятадын найрамдлын 10 хоног”-ийг монгол орон даяар зохион байгуулжээ. Тус арга хэмжээний хүрээнд Хятадын 103 уран бүтээлчдийн бүрэлдэхүүнтэй урлагийн групп Монголд айлчлан тоглоход Өвөр Монгол болон Хятадын бусад хотуудын шилдэг 29 бүжигчин Жя Зуо Гуан удирдан ирсэн байна. Тоглолтод “Жя Зуо Гуаны дэглэсэн “Орчон үндэсний бүжиг”, “Адуучны бүжиг”, “Сэлэмт бүжиг”, “Бэлгийн уут” бүжгүүд тоглосон байна. “Адуучны бүжиг”-ийг Жя Зуо-гуан өөрөө гоцлон бүжиглэжээ”¹.

ӨМӨЗО-ны бүрэлдэхүүнд багтдаг гурван цөөн тоот угсаатан ястны нэг нь Орчон ба Жя Зуо Гуан тэдний амьдралд гүнзгий нэвтэрч, нарийн нягт ажиглаж, материал цуглуулан, тасралтгүй боловсруулсны үр дүнд “Орчон үндэстний бүжиг”-ийг дэглэжээ. Тус бүжиг нь ой шугуйд амьдардаг орчон үндэстний залуучуудын анхийх үйл явцыг харуулсан бүжиг юм. Орчон үндэстний залуучуудын баавгай агнаад баярлан хөөрч, галын наадам хийж, тойрон бүжиж буйг харуулсан уг бүжиг нь залуусын эр бяр, хүч чадлыг илэрхийлсэн бүтээл юм. Тус бүжгийг Өвөр Монголд төдийгүй Хятад улс даяар олон удаа тоглож, үзэгчдийн халуун талархлыг хүртжээ. “Хун галуун бүжиг” бол хун галууны домгоор сэдэвлэн зохиосон гоцлол бүжиг юм. Энэ бүжгийг Жя Зуо Гуан өөрөө анх бүжиглэж, үзэгчдээс гайхамшигтай сайхан бүжиг байна гэсэн үнэлэлт авч байжээ. Галууны дэгдээхэй тэнгэрт хурдан дүүлэн нисэхийг хүсэж, эрмэлзэж буйг илтгэсэн орчин үеийн бүжгийн хөдөлгөөнийг үндэсний бүжгийн намба төрхтэй хослуулан дэглэсэн бүжиг юм.

1950-1960 онд тэрээр “Ордос бүжиг”, “Хундаган бүжиг”, “Саальчин” бүжиг зэрэг алдартай бүтээлүүдээ туурвиснаас 1955 онд Польш улсад зохион байгуулагдсан Дэлхийн залуучуудын оюутны V их наадмын бүжгийн уралдаанаас “Ордос бүжиг” алтан медаль, “Саальчин” бүжиг хүрэл медаль, 1961 онд Дэлхийн залуучуудын оюутны VIII их наадмаас “Хундаган бүжиг” алтан медаль хүртжээ.

1954 онд Жя Зуо Гуан Өвөр Монголын Ордос нутагт очиж сүмийн лам нар баг зүүж, цам харайж байхыг үзжээ. Цамын бүжиг үзсэн нь түүнд сонин содон санагдаж, нэгэн шинэ бүжгийн санаа өгсөн байна. Тэрбээр цамын бүжгийн намба төрх, хөдөлгөөнийг Ордос ардын бүжигтэй нэгтгэн тайзны бүжиг дэглэсэн нь “Ордос бүжиг” юм. Тус бүжиг нь “Гараа даллан их алхмаар явах, сүвээгээ даран мөрөө сэгсрэх” хөдөлгөөнийг гол болгохын хамт, лам нарын “Бугын сахиусны бүжиг” зэргийг ашиглахдаа, зөөлөн айзмыг нь чангаруулж, амьдрал дундах хөдөлгөөнт байдлыг бүжгийн хэл хэллэг ба тэмдэг болгон өөрчилсөн байна. Хятад улсын алдарт бүжиг шүүмжлэгч Фэн Шуан Бай “Ордос бүжгээс шинээр мэндэлсэн төр гүрний итгэлийг мэдэж болно. Учир нь тэр бүжгийг бүжиглэж байгаа нь хурдан ч биш, удаан ч биш, айзам нь баяр баяслаар бялхаж байгаа боловч хөөрүү биш.

1 Эрдэнэхорлоо Ж. Монгол – Хятадын соёл урлагийн харилцаа ба бүжиг // “Өвөр монгол урлаг” эрдэм шинжилгээний сэтгүүл. 2018. № 01. 89-р тал

Биеийн хэмнэл хөдөлгөөн дотор нь хүч чадал агуулагдаж байгаа боловч уяхан зөөлнөө алдаагүй. Бүжиг нь алхам алхмаар залгалдаж, хэсэг хэсгээрээ таны сэтгэл зүрхэнд нэвчинэ. Бүжиглэж дуусах үед та нэгэнт энэхүү баяр баясгалант үндэстний ард түмэнтэй нэг бүрчлэн танилцсан мэт сэтгэгдэл төрнө”² хэмээн бичсэн байдаг.

Тус бүжгийг дэглэснээс хойш жар гаруй жил өнгөрөхөд “Ордос бүжиг”-ийг ардын бүжиг мэт үздэг болсон байна. Мөн Өвөр Монгол төдийгүй Хятад улсын бусад муж орны бүжгийн чуулга болон бага, дунд, их сургууль, ард түмний дунд одоог хүртэл дэлгэрэн тоглогдож байна. Хятад улсын дарга асан Ху Жин Тао их сургуульд суралцаж байхдаа “Ордос бүжиг”-ийг бүжиглэж байсан хэмээн дурссан байдаг.

Жя Зуо Гуаны 1958-1959 оны үед дэглэсэн “Хундаган бүжиг” бол Өвөр Монгол бүжгийн нэг онцгой хэлбэр болох хундагатай бүжиглэх эхлэлийг тавьснаараа ач холбогдолтой. Нэрт бүжиг дэглээч Цэцэнтархиас эхлээд Өвөр Монголын үе үеийн бүжиг дэглээчид “Хундаган бүжиг”-ийг шинэчлэн баяжуулж, Өвөр монгол бүжгийн нэг хэв маяг болгон хөгжүүлж, ямарваа баяр наадмын үйл ажиллагаанд хамгийн түрүүнд бүжиглэдэг болсон билээ.

1960-1970 онд Жя Зуо Гуан “Солонго”, “Баясал”, “Малчин хүү”, “Аян хол ачаа хүнд” зэрэг нэрд гарсан бүжгээ дэглэсэн юм. 1977 онд Жя Зуо Гуан Өвөр Монголын Улаанмөчирт “Солонго” хэмээх ӨМӨЗО-ны бүрэлдэхүүнд ордог, цөөн тоот Эвенк үндэстний эмэгтэйчүүдийн бүжиг дэглэсэн юм. Энэ бүжиг нь хорин хэдэн жилийн өмнөх Эвенк үндэстний амьдрал дундаас тэмдэглэн авсан материалдаа үндэслэн зохиосон бүтээл юм.

1977 онд Жя Зуо Гуан өөрийн шавь Одмөлд “Баясал” гоцлол бүжиг дэглэж өгсөн нь 1980 онд Хятад улсын анхдугаар бүжгийн уралдаанд тэргүүн байрт шалгарчээ. Жя Зуо Гуаны дэглэсэн орчин үеийн бүжигт ч гэсэн монгол үндэстний соёл, сэтгэлгээний онцлог туссан байдаг. Түүний “Аян хол ачаа хүнд” гэдэг бүжгийн хөдөлгөөнийг үзэхэд монгол бүжгийн ул мөр харагдахгүй мэт. Гэвч бүжгийн айзам хэмнэл, утга санааг авч үзвэл өргөн уудам элсэн цөлд яваа тэмээний дүр тодрох бөгөөд тэмээний хүч чадал, тэсвэр тэвчээртэй чанарыг илтгэсэн байдаг.

1980 онд Жя Зуо Гуан “Давалгаа” орчин үеийн бүжиг дэглэсэн нь ихэд алдаршсан юм. Энэ бүжгээр халин нисч байгаа салхич шувуу ба далайн давалгааны дүрслэлээр дамжуулан залуу насны цог золбоог дэлгэн үзүүлж, соёлын хувьсгалын хүнд хэцүү үе дуусч, шинэ нийгмийн гэгээлэг зүйл рүү тэмүүлэх ард түмний хүсэл эрмэлзлэлийг илэрхийлжээ. Тус бүжигт Жя Зуо Гуан монгол бүжиг болон орчин үеийн бүжгийг хослуулжээ.

Жя Зуо Гуаны уран бүтээлийг авч үзэхэд Өвөр Монголд ирээд анх зохиосон “Адуучны бүжиг”-ээс эрин цагийн орчин үеийн бүжгийн шилдэг бүтээл “Давалгаа” хүртэл цөм түүний оюуны хүч чадлаа шавхан бүтээсэн бүтээл юм. Хятадын бүжгийн нэрт зүтгэлтэн Ү Сяо Бан “Түүний бүжиг бол ил тод өвөрмөц, онцлог ба хэв маягтай Жя овогтын бүжгийн урсгалыг бүрэлдүүлсэн байна. Жя овогтын бүжгийн урсгал нь Хятад улсын бүжиг ба Өвөр Монголын бүжгийн түүхэнд чухал байр суурь эзлэхээр барахгүй дэлхийн бүжгийн тавцанд ч томоохон байр суурь эзэлдэг.”³ хэмээн Жя Зуо Гуаны бүжгийн урлагт оруулсан хувь нэмрийг үнэлсэн байна.

2 Фөн Шуан Бай. Жя Зуо Гуаны урлагийн зам. Бээжин., 2002. 102-р тал

3 Ү Сяо Бан. Хятад улсын орчин үеийн бүжгийн онол. Бээжин., 1988. 69-р тал

“Жя Зуо Гуаны уран бүтээлийн зам ба бүжгийн бүтээлээс үзвэл, амьдралд гүнзгийрэх, амьдралыг ойлгох, амьдралаас боловсруулалт хийх, амьдралыг урлагаар илтгэх нь түүний бүжгийн уран бүтээлийн хувиршгүй жам хууль бөгөөд амжилт бүтээлийн эх булаг юм”⁴ хэмээн эрдэмтэн Чүн Бай Хуа дүгнэжээ. Тэр хэдийгээр Монгол үндэстэн биш боловч Өвөр Монголын ард түмэнтэй сэтгэл зүрхээ холбож, бэрхшээлтэй боловч баяр баяслаар бялхам тал нутгийн малчны амьдрал түүний урам зоригийг өдөөж, малчин ард иргэдийн халуун дотно байдал, зан заншил нь түүний уран бүтээлд том нөлөө үзүүлсэн байна.

Түүний уран бүтээлээс хөдөө нутгийн амьдралын онцлогийг мэдрэх болно. Адуучны морь уургалах, эмнэг сургах нь хүч чадал, сүр жавхааны гоо сайхныг үзүүлдэг бол эмэгтэйчүүдийн хонь хяргаж, үнээ саах нь уян зөөлнийг гайхуулна. Тэрбээр энэхүү малчдын бодит амьдралаас уран бүтээлийнхээ сэдэв санааг олдог байсан бөгөөд малчин ардын амьдрал ахуйг судлах явцад түүний амьдралын туршлага улам арвижиж, бүжиг дэглэх авьяас чадвар нь ундарч, урлагийн онцгой бүтээл туурвихад нь нөлөөлсөн байна.

Монгол үгэнд “Шилдэг суртал сар мэт, нандин туршлага нар мэт, хутганы ирний хурц нь билүүнд байдаг, баатрын эрэлхэг нь дайнд байдаг” гэсэн цэцэн үг байдаг. Энэхүү уран үгний утгыг авч үзвэл Жя Зуо Гуан бол тал нутгийн малчдын амьдралын гол зангилааг бүжгээр илэрхийлж чадсан агуу уран бүтээлч юм. Иймээс түүний урлагийн хэв маяг, бүжгийн урсгал нь тал нутгийн ахуй соёл, амьдралын нөлөөн дор хуримтлан бүрэлдсэн байдаг. Түүний өөрийнх нь хэлсэнчлэн “Тал нутгийн ард түмний хүмүүжил байхгүй бол өнөөдрийн Жя Зуо Гуан байж чадахгүй” ажээ.

Жя Зуо Гуаны суурийг нь тавьж өгсөн Өвөр Монголын тайзны бүжгийн хэв маяг, дэг сургуулийг түүний шавь нар болох нэрт бүжиг дэглээч, багш Цэцэнтархи, Цагаанчулуу, Мядагмаа, Одмөл нар цаашид хөгжүүлсэн билээ. Түүний бүтээлүүд өвөр монгол бүжгийн өв уламжлал болсон юм. Бүжгийн хөдөлгөөнд нь задлан шинжлэл хийж, олон арван хөдөлгөөн, элементийг өвөр монгол бүжгийн хичээлийн хөтөлбөрт оруулж, нэр томъёог нь сургалт, судалгаанд хэрэглэж байна.

Жя Зуо Гуаны уран бүтээлийг судлах, суралцах ажил эрчимтэй явагдаж ирлээ. Үүнд:

- 2000 онд Бээжинд “Жя Зуо Гуаны уран бүтээлийн сэтгэмж, санаа” хэмээх эрдэм шинжилгээний хурал болж, “Ардын бүжгийн уран бүтээлчдэд зориулав” гэсэн “Хун галуу” нэртэй уран бүтээлийн үдэшлэг зохиосон байна.
- Хятадын нэрт бүжиг судлаач Фөн Шуан Бай “Жя Зуо Гуаны бүжгийн урлагийн зохиолын түүвэр” (2000), “Жя Зуо Гуаны урлагийн зам” (2002) ном, DVD гаргасан юм.
- 2002 онд “Жя Зуо Гуаны 50 жилийн урлагийн зам” уран бүтээлийн үдэшлэг хийж, Жя Зуо Гуаны баримал бүтээжээ.
- 2006 онд “Хун галуу огторгуйд ниснэ” уран бүтээлийн үдэшлэг хийж, Бээжин, Хөх хотод тоглож, DVD болгон гаргасан юм.
- 2006 онд ХонгКонгод болсон Олон улсын бүжгийн наадмын үеэр Жя Зуо Гуаны бүжгийн урлагийн үзэл, онолын талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулжээ.

4 Чүн Бай Хуа. Урлагийн ахуй. Бээжин., 1999. 77-р тал

- 1994 онд Хятад улсын ХХ зууны 50 шилдэг бүтээл шалгаруулахад Жя Зуо Гуаны “Ордос бүжиг”, “Давалгаа”, “Адуучин” бүжиг орсон бол 2003 онд Хятад улсын “ХХ зууны шилдэг уран бүтээлч” шагнал хүртсэн юм.

Дүгнэлт

ХХ зууны Хятадын бүжгийн урлагийн нэрт зүтгэлтэн Жя Зуо Гуан бол орчин цагийн Өвөр Монголын тайзны бүжгийн суурийг тавьж, хэв маяг, дэг сургуулийг нь бий болгож хөгжүүлсэн уран бүтээлч мөн. Тэрбээр өвөр монгол бүжгийг дэлхийн тавцнаа гаргаж алдаршуулсан билээ. Жя Зуо Гуаны бий болгосон өвөр монгол бүжгийн хэв маяг, дэг сургуулийг шавь нар нь үргэлжлүүлэн хөгжүүлж өнөөгийн түвшинд хүргэжээ. Жя Зуо Гуаны бүтээлүүд өвөр монгол бүжгийн өв уламжлал болж, залуу үеийнхэн уран бүтээл, бүжиг дэглэсэн туршлагыг нь судалж, суралцсаар байна.

Ном зүй

Ү Сяо Бан. (1988) Хятад улсын орчин үеийн бүжгийн онол. Бээжин.

Чүн Бай Хуа. (1999) Урлагийн ахуй. Бээжин.

Фөн Шуан Бай. (2002) Жя Зуо Гуаны урлагийн зам. Бээжин.

Эрдэнэхорлоо Ж. (2018) Монгол-Хятадын соёл урлагийн харилцаа ба бүжиг. “Өвөр монгол урлаг” эрдэм шинжилгээний сэтгүүл. № 01

CLARIFYING THE PERSONAL CONTRIBUTION OF THE FAMOUS CHOREOGRAPHER JIA ZUO GUAN TO THE DEVELOPMENT OF STAGE DANCE OF INNER MONGOLIA

^aOyuntungalag A., ^bXilinfu, ^cErdenekhорloo J.

^aPhD., associate professor, Teachers School, MNUE,

^blecturer, Inner Mongolian University of Arts,

^cPhD., associate professor, The Mongolian State University of Arts and Culture, School of Dance Arts

Corresponding author: oyuntungalaga@msue.edu.mn 

Abstract

Jia Zuo Guan, a well-known figure of Chinese dance, one of the lider of modern dance, laid the foundation and developed the modern stage dance of Inner Mongolia with his choreography, researching the lifestyle, culture and folk dance of the people of Inner Mongolia. Therefore, it is important to deeply study Jia Zuo Guan's Inner Mongolian choreography. In 1947, Jia Zuo Guan came to Inner Mongolia and worked as a dancer and choreographer in the Inner Mongolia Song and Dance Group. He came here and choreographed several famous dances.

Keywords

History, national culture, Mongolian customs, unique national dance and choreography